



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2011 оны 10 сарын 12 өдөр

Дугаар 289

Улаанбаатар хот

Г “Юнайтэд Секьюритс” ХХК-д Г  
брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх  
тусгай зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, 22.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.1, 15.3.5, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20.1, 34.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Юнайтэд Секьюритс” ХХК-д үнэт цаасны зах зээлд брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар олгосугай.

2. Хөрөнгө оруулагч, харилцагчдын хууль ёсны эрх ашгийг дээдлэн, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлэн ажиллахыг “Юнайтэд Секьюритс” ХХК/М.Мөнхбаатар/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар/С.Тулгаа/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газарт тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН